



**НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР ДҮҮРГИЙН
ОНЦГОЙ КОМИССЫН
АЛБАН ДААЛГАВАР**

2026 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

「 Багануур дүүргийн нутаг дэвсгэрт орчны аюулгүй байдлыг хангуулах, эрсдэлийг бууруулах ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.1.1, 27¹.1.4, 28 дугаар зүйлийн 28.1.5, Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 10 дугаар албан даалгавар, Улсын Онцгой комиссын даргын 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 03 дугаар тушаалыг тус тус үндэслэн дүүргийн Онцгой комиссоос ДААЛГАХ нь:

Нэг. Дүүргийн орлогч (Б.Балжинням),
ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс Н.Оюунцэцэг-д:

1.1 Дүүргийн иргэд болон хүүхдийн сурч хөгжих, амьдрах орчны аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор сургууль, цэцэрлэг, тоглоомын талбай, нийтийн эзэмшлийн талбайн камержуулалт, гэрэлтүүлэг, тохижилт, засвар үйлчилгээний ажлыг үе шаттай хэрэгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулах. Дээрх ажлын хэрэгцээ, зардлын тооцооллыг холбогдох байгууллагуудаас гаргуулан нэгтгэж, шаардлагатай хөрөнгийг дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэх, дүүргийн төсвийн тодотголд суулгаж, хэрэгжилтийг хангах.

Хоёр. Дүүргийн менежер (Д. Дэмчигжав),
ЗДТГ-ын Мал эмнэлгийн тасгийн дарга (Ц.Төмөрсүхэд),
Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс, Хороодын Засаг дарга нарт

2.1 Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд дүүргийн хэмжээнд шаардлагатай арга хэмжээний төлөвлөгөөг урьдчилан боловсруулж, холбогдох байгууллагуудын бэлэн байдлыг хангах ажлыг зохион байгуулах;

2.2 Инженерийн шугам сүлжээ, дулаан хангамж, цахилгаан эрчим хүч, авто зам, нийтийн үйлчилгээний байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэлийн явцтай танилцаж, шаардлагатай засвар үйлчилгээ, хөрөнгө оруулалтын ажлын төсөв,

2.3. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдвар тархахаас сэргийлэх зорилгоор дүүргийн хэмжээнд холбогдох

байгууллагуудтай хамтран сэрэмжлүүлэг, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах

2.4. Шүлхий өвчний нөхцөл байдал, халдвар дамжих эрсдэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар иргэд, мал бүхий өрхүүдэд сэрэмжлүүлэг, зөвлөмжийг тогтмол хүргэж ажилласан. Мэдээллийг дүүргийн албан ёсны цахим хуудас, олон нийтийн сүлжээ, баг, хороодын мэдээллийн сувгууд болон мэдээллийн самбараар дамжуулан түгээх зардлын тооцоог гаргах.

2.5. Мөн мал, амьтны шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах, өвчний сэжиг бүхий тохиолдлыг нэн даруй холбогдох байгууллагад мэдээлэх, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөх талаар иргэдэд зөвлөмж өгч ажиллах.

2.6. Шаардлагатай үед холбогдох мэргэжлийн байгууллагуудын гаргасан шийдвэр, зөвлөмж, сэрэмжлүүлгийг тухай бүр нь шуурхай хүргэн ажиллах.

Гурав. Засаг даргын Тамгын газрын дарга (П.Баттүшиг),
Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын
хэлтэс (Б.Туяа)-д:

3.1 Дүүргийн хэмжээнд иргэд болон хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, сурч, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах чиглэлээр сургууль, цэцэрлэг, хүүхэд хамгааллын байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага болон бусад холбогдох байгууллагуудын аюулгүй ажиллагааны нөхцөлд үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх.

3.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх сургалт, сурталчилгаа, дадлага зохион байгуулах, хамгаалах хэрэгсэл, анхааруулах тэмдэг тэмдэглэгээ, аюулгүй ажиллагааны тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах, осол гэмтэл, үйлдвэрлэлийн болон ахуйн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.

3.3 Иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангах тал дээр анхаарч мэдээллийн хэрэгсэл Багануурын мэдээ цахим хуудсаар мэдээ мэдээллийг хүргэж гал түймэр, гамшиг осол, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх аюулгүй байдлыг хангуулах талаар анхааруулга сэрэмжлүүлэг хүргэх, сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;

3.4 Иргэдийн оролцоонд тулгуурлан болзошгүй эрсдэл, аюулын талаарх мэдээллийг шуурхай хүлээн авах, дамжуулах зорилгоор "Багануурын мэдээ" цахим мэдээллийн сувгийн дэргэд "Эрсдэлгүй Багануур" мэдээллийн хуудсыг ажиллуулж, иргэдээс санал, хүсэлт, сэрэмжлүүлэг, эрсдэл бүхий газар орчны талаарх мэдээллийг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх;

Дөрөв. Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс,
Боловсролын хэлтсийн дарга (Ц.Ононтунгалаг),

4.1 Дүүргийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуулиудын орчинд аюулгүй байдлын үзлэг, шалгалтыг зохион байгуулж, хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй нөхцөл байдлыг тодорхойлох;

4.2 Үзлэг шалгалтаар сургуулийн орчны авто замын хөдөлгөөн, явган хүний гарц, гэрэлтүүлэг, тоглоомын талбай, орц гарц, орчны тохижилт, хашаа хашлага камержуулалтын нөхцөл байдалд үнэлгээ хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар холбогдох байгууллагуудад санал, зөвлөмж хүргүүлэх;

4.3 Хүүхэд хамгааллын чиглэлээр сургуулийн орчны аюулгүй байдлыг сайжруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хяналтын камерын ашиглалт, хамрах хүрээг нэмэгдүүлэх асуудлыг холбогдох байгууллагуудад уламжилж, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр хамтран ажиллах;

4.4 Сургууль, цэцэрлэгийн орчимд хүнс үйлдвэрлэл, худалдаа, түргэн хоолны үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийн хүнсний чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт зохион байгуулж, хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн, зөрчил дутагдлыг арилгуулах ажлыг зохион байгуулах.

Тав. Хороодын Засаг дарга нар,
Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс (Б.Мөнхчимэг),
Багануур тохижилт "ААТҮГ" (Д.Олзвой), Хөдөлмөр халамжийн
үйлчилгээний газар (С.Ичинхорлоо), Теле камерын хяналтын дэд төв
ОНӨТҮГ (Ц.Батбуян), Сууц өмчлөгчдийн холбоод, "Боршоон-Ундраа" ХХК
(Д.Батнасан), Багануур цахилгаан түгээх сүлжээ
салбарын дарга (Х.Төгсжаргал)-д:

5.1. Дутуу баригдсан барилга байгууламжид үзлэг шалгалтыг зохион байгуулах эзэмшигч иргэн, хуулийн этгээдэд улсын хяналтын байцаагчийн мэдэгдэл заавар зөвлөмж хүргүүлэх;

5.2 Дүүргийн хэмжээнд орон сууцны байрны цахилгааны самбар, цахилгаан дамжуулах шугам сүлжээ, ил задгай утас, гадна гэрэлтүүлгийн шонгийн ашиглалт, аюулгүй байдлын нөхцөлд үзлэг шалгалтыг зохион байгуулж, цахилгааны самбарын цоож, түгжээний бүрэн бүтэн байдал, хамгаалалтын шаардлага хангаж байгаа эсэх, ил задгай цахилгааны утас байгаа эсэх, гэрлийн шонгийн мурийлт, гэмтэл, эвдрэл зэргийг шалгаж эрсдэл бүхий нөхцөлүүдийг тогтоох;

5.3 Холбогдох сууц өмчлөгчдийн холбоо болон мэргэжлийн байгууллагуудад мэдэгдэж, засвар үйлчилгээ, хамгаалалтын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх талаар чиглэл хүргүүлж, иргэдийн амь нас, эрүүл мэндэд эрсдэл учруулж болзошгүй нөхцөл байдлыг арилгах, цахилгааны аюулгүй байдлыг хангах чиглэлээр хяналт тавьж ажиллах;

5.4 Дүүргийн нутаг дэвсгэр дэх дулаан, цэвэр болон бохир усны шугамын худаг, инженерийн байгууламжийн тагны бүрэн бүтэн байдал, мөн ухсан нүх, далан, суваг шуудууны аюулгүй байдлын нөхцөлд үзлэг шалгалт хийх;

5.5 Үзлэгийн үеэр эвдэрсэн, гэмтсэн, таггүй болон хамгаалалтгүй худгууд, иргэдийн аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй байршлуудыг илрүүлж, холбогдох байгууллагуудад мэдээлэн засварлах, нөхөн сэргээх, хамгаалалтын хаалт, тэмдэг тэмдэглэгээ байршуулах талаар шаардлага хүргүүлж, эрсдэл бүхий хүчин зүйлсийг бууруулах чиглэлээр хяналт тавьж, засвар үйлчилгээний ажлыг үе шаттай зохион байгуулах;

5.6 Хүүхэд багачуудын аюулгүй орчинд тоглох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор камержуулалт шаардлагатай байршлуудын судалгааг гаргаж, хяналтын камер шинээр суурилуулах болон хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар санал ирүүлэх;

5.7 Дүүргийн хэмжээнд эзэнгүй золбин нохой, муурын тоо толгойг бууруулах, иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран золбин нохой, муур устгалын ажлыг зохион байгуулах.

5.8 Хороодоор дамжуулан айл өрхүүдэд нохойгоо байнгын хүзүүвчтэй байлгах, бүртгэлжүүлэх, сул тавихгүй байх, олон нийтийн газарт авч явахдаа эзний хяналттай байлгах талаар сэрэмжлүүлэг, зөвлөмжийг хүргэн ажиллах.

5.19 Иргэдэд гэрийн тэжээвэр амьтны асаргаа, мал эмнэлгийн үйлчилгээ, вакцинжуулалтад хамруулах, хүн, амьтанд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах.

5.10 Үерийн улмаас гудамж, авто зам, талбайд үүссэн ахуйн хог хаягдал, лаг шавар, шороог тухай бүр цэвэрлэж, зорчих хөдөлгөөний хэвийн ажиллагааг хангах.

5.11 Дүүргийн үерийн усны гаргалгаа болон далан шуудууны хаягдал хог, дагтаршсан шороог гаргаж цэвэрлэж шар усны урсах замыг хэвийн голдирол оруулж иргэдийн эд хөрөнгийг үер усны аюулд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.

Зургаа. Багануур ХК-ний гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч
(Т.Отгонболд) 2,3 дугаар хорооны Засаг дарга нарт

6.1 Уул уурхайн ашиглалт, нөхөн сэргээлт хийгдэж буй талбай болон хамгаалалтын бүсийн аюулгүй байдлыг хангах зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран үзлэг шалгалтыг зохион байгуулж, уурхайн хязгаарлалтын бүсийн тэмдэг тэмдэглэгээ, хамгаалалтын хашаа, анхааруулах самбарын бүрэн бүтэн байдал болон иргэд, тэжээвэр мал амьтан нэвтрэх эрсдэлтэй нөхцөл байдлыг шалгаж ажиллах;

6.2 Уурхайн үйл ажиллагаанаас шалтгаалан үүсэж болзошгүй осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор уурхайн хязгаарлалтын бүс орчимд тэжээвэр мал, амьтан бэлчээхгүй байх талаар мал бүхий иргэдэд сэрэмжлүүлэг, зөвлөмж өгч, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулан, илэрсэн зөрчил дутагдлыг арилган эрсдэлийг бууруулах;

6.3 Дүүргийн 2,3 дугаар хорооны иргэдэд уурхайн хязгаарлалтын бүсэд зөвшөөрөлгүй нэвтрэхгүй байх, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг мөрдөх талаар мэдээлэл, сэрэмжлүүлгийг тогтмол хүргэн мэдээллийг хорооны мэдээллийн самбар, цахим хуудас, олон нийтийн сүлжээ болон иргэдийн уулзалт, өдөрлөгөөр дамжуулан хүргэж, уурхайн бүсэд нэвтрэх үед учирч болзошгүй осол, эрсдэлийн талаар анхааруулж, уурхайн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөх, хүүхэд болон иргэдийг зөвшөөрөлгүйгээр уурхайн талбай руу нэвтрүүлэхгүй байх талаар иргэдэд зөвлөмж өгч ажиллах;

Долоо. Хороодын Засаг дарга нар, Цагдаагийн хэлтэс (Н.Батхишиг),
Тээвэр зохицуулалтын алба ААТҮГ, Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын
хэлтэс (Т.Хашлянхуа)-д

7.1 Дүүргийн нутаг дэвсгэрийн гудамж, талбай, олон нийтийн газруудын аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж ажиллах.

7.2 Хэсгийн ахлагч, хороодын ажилтан, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран эргүүл, хяналт шалгалтыг зохион байгуулж, гэмт хэрэг, зөрчил гарах эрсдэлтэй байршлуудын нөхцөл байдалд үнэлгээ хийх.

7.3 Иргэдийн аюулгүй зорчих орчныг бүрдүүлэх зорилгоор гэрэлтүүлэг, камержуулалт, орчны тохижилтын асуудлаар санал боловсруулан танилцуулах;

7.4 Хороо, өрхийн эрүүл мэндийн төв, цагдаа, нийгмийн ажилтан болон бусад холбогдох байгууллагын төлөөллөөс бүрдсэн хамтарсан баг эрсдэлтэй нөхцөлд амьдарч буй айл өрхүүдэд хүрч ажиллах

7.5 Өрхийн нөхцөл байдалтай танилцаж, хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, архидалт, эрүүл мэнд болон нийгмийн халамжийн үйлчилгээний талаар зөвлөгөө өгч, шаардлагатай мэдээлэл, зөвлөмжөөр ханган ажиллаж эрсдэлт нөхцөлийг бууруулах чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах

7.6 Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй худалдаа, үйлчилгээний байгууллагуудад насанд хүрээгүй хүнд архи, согтууруулах ундаа болон тамхи худалдахгүй байх талаар мэдээлэл, зөвлөмж хүргэж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллах

7.7 Хяналт шалгалтын үеэр үйлчилгээ эрхлэгч нарт санамж, зөвлөмж өгч, иргэний үнэмлэх шалгаж үйлчлэх, хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж өгч, илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох арга хэмжээ авч, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.

7.8 Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагууд болон хот хоорондын зорчигч тээврийн жолооч нарт ариун цэвэр, аюулгүй ажиллагааны шаардлагыг мөрдүүлэх чиглэлээр мэдээлэл, зөвлөмж хүргэн ажиллах.

7.9 Хот хоорондын нийтийн тээврийн хэрэгсэл болон хувиараа зорчигч тээвэрлэх үйлчилгээ эрхлэгч иргэдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, хараа хяналтгүй бага насны хүүхэд зорчихоос урьдчилан сэргийлэх, зорчигчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр хөдөлгөөнд оролцохын өмнө суудлын бүс хэрэглэх талаар тогтмол сануулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулж, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн болон хяналт шалгалтын арга хэмжээг зохион байгуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

7.10 Тээврийн хэрэгслийн дотоод орчны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийх, техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах талаар тээвэр эрхлэгч байгууллагуудад зөвлөмж өгч, холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавин ажиллах.

Найм. Цаг уурын өртөө (Х.Энхчимэг)-д:

8.1 Цаг агаарын сэрэмжлүүлэг, анхааруулга, зөвлөмжийг дүүргийн албан ёсны цахим хуудас, олон нийтийн сүлжээ, мэдээллийн сувгууд болон багц

мессежийн үйлчилгээгээр дамжуулан иргэдэд шуурхай түгээж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран тухай бүр шуурхай авч, хүчтэй салхи, аадар бороо, үер ус, цасан болон шороон шуурга, хэт халалт, хүйтрэлт зэрэг аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг дүүргийн иргэдэд тогтмол хүргэх;

Энэхүү албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, мэдээ, тайланг Дүүргийн Онцгой комиссын ажлын алба (Онцгой байдлын хэлтэст) 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг холбогдох КОМИССЫН гишүүд, дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН